



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Г “Манхан хөгжил” хоршооны хадгаламж 7  
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Манхан хөгжил” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан хоршоог холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах, шаардлагатай гэж үзвэл татан буулгах комисс томилон ажиллуулж, өр төлбөрийг зохих журмын дагуу бүрэн барагдуулж, Улсын бүртгэлээс хасуулах арга хэмжээ авахыг “Манхан хөгжил” хоршоо /Ж.Бямбасүрэн/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН